

Гэр бүлийн боловсрол  
**Эцэг эхийн мэдээлэл болон сурагчийг хичээлээс чөлөөлөх журам**

Virginia муж улсын шаардлагын дагуу, Арлингтоны Сургуулийн Зөвлөлөөс Гэр бүлийн боловсролын хөтөлбөрийг батлан гаргалаа. Гэр бүлийн боловсролын хичээлээр орох зарим сэдэвт ойр тойрныхонтойгоо бий болгох харилцаа, бэлгийн харилцаа, нөхөн үржихүй, үе тэнгийнхний дарамтыг давж гарах, аливаа бодисыг буруугаар ашиглах зэрэг орно.

Гэр бүлийн боловсролын сургалтын стандарт, сургалтын материалууд (сургалтын стандартууд, хичээлийн төлөвлөгөө, сурах бичиг, гарын авлага гэх мэт)-ийг хүүхдийнхээ сургууль болон Syphax боловсролын төвөөс авч болно.

Хүүхдийн тань сургууль Гэр бүлийн боловсролын хөтөлбөрийн талаарх хурлыг жил бүр хийнэ. Энэхүү хурлын үеэр та бүхэн ямар хичээл заах талаар болон эцэг эхийн хувьд энэхүү хичээлээр олсон мэдлэгийг хэрхэн дэмжиж болох талаарх мэдээллийг олж авах боломжтой. Эхний өдрийн мэдээллийн багцад уг хөтөлбөрийг тайлбарласан мэдээлэл багтах бөгөөд хичээлийн хөтөлбөрийн материалуудыг үзэх боломжтойг сануулсан захидлыг та бүхэн хүлээн авах болно.

Хэдийгээр Гэр бүлийн боловсролын хөтөлбөр эцэг эх та бүхний хүүхдээ хүмүүжүүлэх явцад тань туслахад зориулагдсан боловч зарим эцэг эх хүүхдээ энэхүү хөтөлбөрийн зарим хичээлээс чөлөөлүүлэх сонголтыг хийж болох юм. Хичээлээс чөлөөлөх маягт эцэг эхчүүдэд энэхүү сонголтоо хэрэгжүүлэх боломж олгоно. Хичээлээс чөлөөлүүлэх маягтыг вэб сайтаас мөн хүсэлт гаргасан тохиолдолд хүүхдийнхээ сургуулиас авч болно. Хичээлээс чөлөөлүүлэх сонголт хийхээсээ өмнө хүүхэд тань боловсролын ямар боломжийг алдах гэж байгааг сайтар тунгаана уу.

Хэрвээ та Гэр бүлийн боловсролын хөтөлбөрийн аль нэг хичээлээс чөлөөлөгдөх сонголт хийвэл, хүүхэд тань үүний оронд сургуулийн мэдээллийн төв зэрэг танхимын бус бусад газарт уг цагийг өнгөрүүлэх болно. Уг хичээлээс хүүхэд тань чөлөөлөгдлөө гэхэд ямар нэг шийтгэл амсахгүй боловч тэд энэхүү цагийг насанд хүрэгсдийн хараа хяналт маш бага орчинд бие даан өнгөрөөх болохыг анхаарна уу. Хүүхэддээ энэхүү хариуцлагыг сануулах замаар та сургуулийн үйл ажиллагаанд тусалцаа үзүүлж болох юм.

Зорилгуудтай сайтар танилцана уу. Хүүхдийн тань сургууль дээр явагддаг Гэр бүлийн боловсролын хөтөлбөрийн талаарх хуралд оролцож хичээлийн хөтөлбөртэй танилцаарай. Хүүхдэд тань уг хөтөлбөр чухал гэдэгт сургуулийн зүгээс итгэж байгаа болно. Түүнчлэн хүүхдэд тань энэхүү хөтөлбөрийг ороход эцэг эхийн зүгээс тусална гэдэгт бид найдаж байна.

Хэрвээ танд энэ талаар ямар нэг асуулт байвал багш, захирал эсвэл Дебора ДеФранкотой (703) 228-6165 утсаар холбогдож болно.